

БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны дугаар сарын ...

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛД ХЯНАЛТ
ТАВИХ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.05.10

Улаанбаатар хот


Ажлын цар хүрээ:


Баянзүрх дүүргийн гудамж, зам талбайн цэвэрлэгээний ажлын гэрээт хугацаанд “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу хяналт тавьж, үнэлэх, дүгнэх, гүйцэтгэгчийг мэргэжил, арга зүйгээр хангах, зөвлөмж, дүгнэлт өгөх, холбогдох стандарт шаардлагыг хангуулж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам стандартын зааврыг мөрдлөг болгоно.

Зөвлөх үйлчилгээний нэр:	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээний ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний ажил
Захиалагч байгууллага	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
Зорилго	Баянзүрх дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээний хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, дүгнэлт хийх, хяналт тавих, үр дүнг үнэлэх
Үндэслэл, хэрэгцээ шаардлага	<ul style="list-style-type: none">Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Чиг үүрэг шилжүүлэх тухай” А/1461 дүгээр захирамжУлаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Чиг үүрэг шилжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/293 дугаар тушаал
Хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
Ажлын хамрах хүрээ	Зөвлөх нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: <ol style="list-style-type: none">Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд хяналт тавих, зөвлөгөө өгөхДүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн хэмжилт хийх (шаардлагатай тохиолдолд)Захиалагчаас цаг үеийн шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, цаг тухай бүрд мэдээлэх, бүртгэл хөтлөхГэрээт аж ахуйн нэгж, байгууллагуудыг болон захиалагч байгууллагыг мэдээллээр хангах, өдөр тутмын хийсэн ажилбар, мэдээлэл, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавих, зөвлөмж, дүгнэлт өгөх;Гудамж талбайд гарсан зөрчлийг илрүүлж, хэмжилт, тооллого хийх, мэргэжлийн байгууллагаар хохирлын үнэлгээг тогтоолгож, захиалагч байгууллагад хүргүүлэх

	<ol style="list-style-type: none"> 6. Гэрээт аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын гүйцэтгэлийг сар бүрийн 05-ны дотор хянан дүгнэж, захиалагч байгууллагад ирүүлэх, гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэх 7. Хот нийтийн аж ахуйн байгууллагуудын шуурхай болон захиалагчаас цаг үеийн шинжтэй зарласан хуралд оролцох, тайлан, танилцуулга бэлтгэх 8. Захиалагчид улирал бүр хийсэн ажлыг тайлагнах, танилцуулга бэлтгэх 9. Талбайд ажиллаж байгаа аж ахуйн нэгж болон ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хангагдсан эсэх, анхан шатны ажлын байрны зааварчилгаа авч ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих 10. Менежмент сайжруулах төлөвлөгөө, зөвлөмж боловсруулах 11. Зам талбайн цэвэрлэгээний технологийн картыг хөгжүүлэх, мөрдүүлэх 12. Шаардлагатай үед иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг зөвлөгөө, мэргэжил арга зүйгээр хангах 13. Бүх нийтийн их цэвэрлэгээний үйл ажиллагаанд хяналт тавих, цэвэрлэгээнд оролцоогүй, зөрчилтэй аж ахуйн нэгж байгууллагуудад мэдэгдэх хуудас өгөх, бүртгэх, зөрчлийг арилгуулах 14. Авто зам дагуух аж ахуйн нэгж байгууллагуудад орчны цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах талаар шаардлага тавин ажиллах
Зөвлөхөд тавигдах шаардлага	<p>Хяналтын үйлчилгээ үзүүлэх байгууллагад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөц, техник хэрэгсэлтэй байх • Цас, мөс, шуурга, шавар, үер ус, халтиргаа гулгаатай үед ажиллах чадамжтай байх • Зам талбайн цэвэрлэгээтэй холбоотой арга зүй мэдээ, мэдээллийг зам талбайн цэвэрлэгээний байгууллагуудад хүргэж, мэргэжил арга зүйгээр хангах ур чадвартай байх
Төсөв	Санхүүжилт нь зам талбай цэвэрлэх зардлын захиалагчийн хяналтын зардал байна.
Зам талбайн цэвэрлэгээний ажилд мөрдөгдөж буй стандарт	<ul style="list-style-type: none"> • Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2020 оны “Энгийн хог хаягдлыг, ангилах, цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам” 32/03 дугаар тогтоол • Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж UCS1704A • Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент UCS1701A
Үр дүнг тайлагнах:	<p>Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн зөвлөх нь Захиалагчаас өгөх чиглэл, зааврын дагуу ажиллана.</p> <p>Сар бүр гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ, түүнтэй холбогдох баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж</p>

ажиллана.

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
ТАСГИЙН ДАРГА  М.БАТ-ЭРДЭНЭ